



COVID-19 цар тахлын дэгдэлттэй холбогдуулан Монгол Улсын 2020 оны эхний 5 сарын эдийн засаг, нийгмийн төлөв байдлыг

танилцуулъя.

ҮСХ-ноос 2020 оны 6-р сарын 12-ны өдөр тархаасан нийгэм, эдийн засгийн байдлын статистик мэдээллээр 2020 оны эхний 5 сарын байдлаар улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс


- Инфляц 3.3%,
- Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 19.0%,
- Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 34.6%,
- Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 16.1%,
- Экспорт 38.5%,
- Импорт 13.9% тус тус буурч,
- Улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээлийн хэмжээ 29.3%,
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 39.5%,
- Ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон тэтгэмжийн хэмжээ 39.0% тус тус өсжээ.



## 1. УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 2020 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 3.3 их наяд төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4.9 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1.6 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Зураг 1. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, тэрбум төгрөг



орлого 23.5 (8.1%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 85.7 хувийг татварын орлого бүрдүүлж байгаа бөгөөд татварын нийт орлого 2020 оны эхний 5 сард 3.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 533.3 (14.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд бусад татвар, төлбөр хураамжийн орлого 116.2 (31.2%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 84.7 (10.4%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 62.8 (18.3%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 60.2 (8.1%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны

Бусад татвар, төлбөр хураамжийн орлого 31.2 хувиар буурахад АМНАТ-ын орлого 103.9 (45.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

НӨАТ-ын орлого энэ оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 10.4 хувиар буурахад дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ 5.9 хувиар, импортын барааны НӨАТ 7.2 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

ОАТ-ын орлого 18.3 хувиар буурахад дотоодын архи, дарсны ОАТ 28.0 хувь, дотоодын тамхины ОАТ 29.4 хувь, дотоодын пивоны ОАТ 10.6 хувь, импортын архи, дарсны ОАТ 8.1 хувь, суудлын автомашины ОАТ 32.2 хувь, автобензин, дизелийн түлшний ОАТ 5.2 хувиар тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлагын өсөлтөд урсгал зардал 873.2 (27.3%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 301.8 (57.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Хөрөнгийн зардал өсөхөд их засварын зардал 2.0 (8.3%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч барилга байгууламжийн зардал 209.8 (52.9%) тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийн зардал 26.1 (2.3 дахин) тэрбум төгрөг, бусад хөрөнгийн зардал 66.1 (90.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн 2020 оны зарлагад хөрөнгийн зардлыг 2019 оноос 17.3 хувиар өсгөн 3.8 их наяд төгрөг байхаар тооцсон байна. Гэвч энэ оны эхний 5 сарын байдлаар хөрөнгийн зардал өмнөх оны мөн үеэс 57.6 хувиар өссөн байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны 5 дугаар сард 697.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 54.6 (8.5%) тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 631.6 (65.1%) тэрбум төгрөгөөр өсжээ.

## 2. ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 230.3 (16.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд төмрийн үйлдвэрлэл, тамхи, химийн бүтээгдэхүүн, резин болон хуванцар бүтээгдэхүүн, хувцас, тавилга, нэхмэлийн үйлдвэрлэл 2.9-52.5 хувиар буурсан байна.

Харин хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэл 2020 оны эхний 5 сард 620.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 469.6 (0.1%) сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар

Салбар	2019		2020*		2020*I-V 2019 I-V
	V	I-V	V	I-V	
	тэрбум төгрөг				хувь
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	137.5	620.8	121.0	620.4	99.9
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	17.4	82.8	13.0	59.9	72.3
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	18.9	92.5	21.8	96.5	104.3
Үр тарианы гурил, малын тэжээл	15.6	81.8	19.6	94.7	115.7
Хүнсний бусад бүтээгдэхүүн	19.6	83.3	18.9	90.4	108.5
Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	66.1	280.4	47.8	278.9	99.5

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурахад сүү, сүүн бүтээгдэхүүн, үр тарианы гурил, малын тэжээл, хүнсний бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4.3-15.7 хувиар өссөн хэдий ч ундаа үйлдвэрлэл (согтууруулах ундаа ороод) 0.5 хувиар мах, загас, ногоо, тос боловсруулалт 27.7 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2019		2020*		2020*I-V / 2019 I-V
		V	I-V	V	I-V	хувь
Үхрийн мах	т	75.7	242.6	60.5	725.9	3.0 <sup>1</sup>
Хонины мах	т	175.7	1 330.0	669.4	1 866.8	140.4
Адууны мах	т	1 050.0	5 408.8	0.0	342.5	6.3
Ямааны мах	т	188.8	298.1	25.4	566.9	190.2
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	т	427.9	2 071.7	497.3	2 023.9	97.7
Шингэн сүү	мян.л	3 907.8	16 786.1	4 281.4	19 036.9	113.4
Тараг	мян.л	1 328.3	6 340.8	1 639.6	6 834.8	107.8
Зайрмаг	мян.ш	13 191.8	36 280.4	15 050.8	36 753.7	101.3
Аарц	т	19.8	180.6	29.1	224.1	124.1
Дээд гурил	т	4 458.8	18 945.0	5 502.2	21 396.3	112.9
Нэгдүгээр гурил	т	10 682.1	57 760.8	12 285.9	63 892.8	110.6
Хоёрдугаар гурил	т	976.5	5 615.1	2 006.8	10 331.6	184.0
Талх	т	2 598.9	11 012.6	2 529.1	11 064.8	100.5
Нарийн боов	т	2 060.9	8 887.5	2 083.7	9 230.6	103.9
Бялуу	т	223.0	939.8	272.6	1 059.8	112.8
Жигнэмэг	т	110.3	447.0	62.4	411.7	92.1
Гоймон	т	773.5	3 612.6	313.2	2 714.8	75.1
Бууз, банш	т	472.5	1 958.9	333.7	1 302.5	66.5
Савласан ногоон цай	кг	9 510.9	38 172.9	13 181.2	70 624.4	185.0
Спирт	мян.л	1 227.7	4 702.8	270.3	4 883.2	103.8
Архи	мян.л	2 507.3	11 435.2	1 760.8	9 727.6	85.1
Шар айраг	мян.л	10 158.1	36 618.4	7 625.6	33 086.3	90.4
Цэвэр ус	мян.л	8 222.7	30 587.1	5 760.4	29 443.3	96.3
Амтат ус, ундаа	мян.л	16 122.3	66 729.7	23 370.5	97 421.7	146.0
Жүүс	мян.л	6 929.0	28 083.2	3 035.7	27 333.4	97.3


<sup>1</sup> Дахин их

Талх, зайрмаг, спирт, нарийн боов, тараг, нэгдүгээр гурил, бялуу, дээд гурил, шингэн сүү, аарц, хонины мах, амтат ус, ундаа, хоёрдугаар гурил, савласан ногоон цай, ямааны болон үхрийн махны үйлдвэрлэл 2020 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 0.5 хувиас 3.0 дахин өссөн байна. Харин хиаман бүтээгдэхүүн, цэвэр ус, жүүс, жигнэмэг, шар айраг, архи, гоймон, бууз, банш, адууны махны үйлдвэрлэл 2.3-93.7 хувиар буурсан байна.

### 3. ИНФЛЯЦ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 5 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.1 хувь, өмнөх оны эцсээс 2.4 хувь, өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өссөн байна.


Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Инфляцын түвшин 2017 оны 5 дугаар сард 3.6 хувь, 2018 оны 5 дугаар сард 6.1 хувь, 2019 оны 5 дугаар сард 8.0 хувь гарч байсан бол 2020 оны 5 дугаар сард 3.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 4.7 пунктээр буурсан байна.

Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2020 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өссөн хэдий ч инфляцад үзүүлж буй оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 19.2 пунктээр буурсан байна.

Зураг 3. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019, 2020 оны 5 дугаар сард



Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 32 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2020 оны 06 дугаар сарын II долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 8 нэрийн барааны үнэ (25.0%) **тогтвортой**, 10 нэрийн барааны үнэ (31.2%) **буурсан**, 14 нэрийн барааны үнэ (43.8%) **өссөн** байна.

≈ Үнэ тогтвортой	↓ Үнэ буурсан	↑ Үнэ өссөн
<ul style="list-style-type: none"> <li>“Алтан Тариа” задгай гурил I</li> <li>“Алтан Тариа” савласан гурил I</li> <li>“Алтан Тариа” савласан гурил I</li> <li>Цагаа будаа, “Заантай”</li> <li>Шар будаа</li> <li>Цөцгийн тос, “Сүү” ХК</li> <li>Ямааны мах, ястай</li> <li>Алим, фүжи</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>“Алтан Тариа” задгай гурил дээд</li> <li>“Алтан Тариа” савласан гурил дээдийн дээд</li> <li>“Алтан Тариа” савласан гурил дээд</li> <li>“Сүү” ХК савласан 0.5 л сүү</li> <li>Сүү, задгай</li> <li>Талх, “Атар”</li> <li>Ургамлын тос, “Янта”</li> <li>Ногоон цай, “Сtimo”</li> <li>Элсэн чихэр, “Заантай”</li> <li>Өндөг, ОХУ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>“Сүү” ХК савласан 1 л сүү</li> <li>“Сүү” ХК тараг, Цөцгийтэй</li> <li>Талх, “Зууван чех”</li> <li>Талх, “хөх тарианы хар”</li> <li>Хонины мах, ястай</li> <li>Хонины мах, цул</li> <li>Үхрийн мах, ястай</li> <li>Үхрийн мах, цул</li> <li>Адууны мах, ястай</li> <li>Төмс, монгол</li> <li>Байцаа, монгол</li> <li>Хүрэн манжин, монгол</li> <li>Сонгино, хятад</li> </ul>

Хонины ястай махны үнэ 2020 оны 6-р сарын II долоо хоногт нэг килограмм нь дунджаар 10393 төгрөг болж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 164 төгрөгөөр (1.6%), хонины цул махны үнэ 106 төгрөгөөр (1.0%) тус тус өссөн байв. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины ястай мах “Хархорин” хүнсний захад хамгийн хямд буюу 8500 төгрөгөөр, харин “Саруул” худалдааны төвд хамгийн өндөр үнэтэй буюу 14500 төгрөгөөр худалдаалж байна.

Хүснэгт 3. Нэг килограмм хонины ястай махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	9 820	10 430	10 045	9 700	9 640	9 095	7 710	7 635
2020	8 705	9 600	9 765	9 835	10 125	10 393*						

Үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 12640 төгрөгийн үнэтэй байгаа ба өмнөх долоо хоногтой харьцуулахад 260 төгрөгөөр (2.1%), үхрийн цул махны үнэ 168 төгрөгөөр (1.1%) тус тус өссөн байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн ястай мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 10800 төгрөг, Харин "Саруул" худалдааны төвд хамгийн өндөр үнэтэй буюу 15500 төгрөг байна.

Хүснэгт 4. Нэг килограмм үхрийн ястай махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	10 960	11 700	12 280	11 540	11 375	10 950	10 090	9 755
2020	10 535	11 415	11 663	11 735	11 940	12 640*						

Үнийн судалгааны сагс дахь нийт 373 нэр төрлийн бараа, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг. Энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлдэг. Инфляц 2020 оны 5 дугаар сард 3.3 хувь гарсны 21.2 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 12.6 пунктээр буурсан байна.

Хүснэгт 5. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 5 дугаар сард

Үзүүлэлт	2018 V		2019 V		2020 V	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	6.1	100.0	8.0	100.0	3.3	100.0
Импортын барааны нөлөө	2.4	39.3	2.7	33.8	0.7	21.2

#### 4. ЭКСПОРТ, ИМПОРТ

БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн удаашрал, COVID-19 цар тахлын сөрөг үр дагаврын нөлөөллөөр гадаад худалдааны нөхцөл муудаж, экспорт буурснаар төлбөрийн үрсгал тэнцлийн алдагдал 2020 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 874.1 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 442.3 сая америк доллароор өссөн байна.

Манай улс 2020 оны эхний 5 сард нийт 131 улстай худалдаа хийсэн ч нийт бараа эргэлтийн 58.4 хувийг БНХАУ эзэлж байна. Нийт бараа эргэлт 4.0 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (28.3%) тэрбум америк доллароор буурахад БНХАУ-тай хийсэн нийт экспорт 1.3 (44.0%) тэрбум америк доллароор, импорт 46.3 (6.4%) сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 6. Экспортын гол түнш улсууд, жил бүрийн эхний 4 сарын байдлаар


Улс орон	2018 I-V		2019 I-V		2020* I-V	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн БНХАУ	2 885.2	100.0	3 263.4	100.0	2 006.3	100.0
Швейцар	2 643.7	91.6	2 960.6	90.7	1 658.5	82.7
Сингапур	0.5	0.0	0.2	0.0	157.7	7.9
Их Британи	11.9	0.4	14.2	0.4	70.5	3.5
ОХУ	155.2	5.4	210.4	6.4	62.6	3.1
Бусад	32.5	1.1	29.5	0.9	21.3	1.1
	41.3	1.4	48.5	1.5	35.6	1.8

БНХАУ-д хийсэн экспорт нь манай улсын нийт экспортын дүнгийн 82.7 хувийг бүрдүүлж байна.

БНХАУ-д гаргасан бараа бүтээгдэхүүний 29.8 хувийг чулуун нүүрс, 37.1 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Швейцар улсад экспортолсон барааны 99.9 хувийг, Сингапур улсад

экспортолсон барааны 85.0 хувийг, Их Британи улсад экспортолсон барааны 77.0 хувийг алтны экспорт эзэлж байна.

Зураг 4. Уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, сая америк доллароор, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Экспорт 2020 оны эхний 5 сард 2.0 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (38.5%) тэрбум америк доллароор буурсан байна. Нийт экспортын 80.6 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлдэг бөгөөд энэхүү бууралтад зэсийн баяжмалын экспорт 278.6 сая америк доллар, нүүрсний экспорт 761.0 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Импорт 2020 оны эхний 5 сард 2.0 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 322.6 (13.9%) сая америк доллароор буурахад автобензины импорт 29.7 сая америк доллар, дизелийн түлшний импорт 84.2 сая америк доллар, суудлын автомашины импорт 71.3 сая америк доллар, ачааны автомашины импорт 25.7 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад цагаан будаа, ургамлын тос, элсэн чихэр, гахайн мах, улаан буудайн импорт 19.9 хувиас 73.9 дахин өсөж, харин өндөг, шувууны мах, хуурай сүү, төмсний импорт 3.2-98.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 7. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний импорт, мян.ам доллар

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018 I-V		2019 I-V		2020* I-V		2020* I-V / 2019 I-V %	
		Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
Улаан буудай	мян.тонн	207.6	40 164.5	1.2	242.9	85.3	17 492.3	73.9 <sup>1</sup>	72.0 <sup>1</sup>
Гахайн мах	тонн	2 951.0	4 357.8	1 223.5	2 462.7	2 582.4	5 607.8	2.1 <sup>1</sup>	2.3 <sup>1</sup>
Шувууны мах	тонн	4 139.1	7 373.6	5 081.1	10 007.5	4 808.4	8 368.2	94.6	83.6
Өндөг	сая.шир	60.5	4 219.7	64.6	4 426.5	62.6	3 996.6	96.8	90.3
Төмс	тонн	1 139.2	289.3	331.8	64.3	4.3	0.8	1.3	1.2
Хуурай сүү	тонн	2 579.7	6 833.6	3 754.4	9 736.7	1 756.9	5 290.4	46.8	54.3
Цагаан будаа	тонн	13 251.2	8 065.2	13 236.6	7 369.7	15 866.4	8 432.9	119.9	114.4
Ургамлын тос	тонн	5 403.1	5 217.8	4 982.5	4 492.5	6 174.3	5 510.1	123.9	122.7
Элсэн чихэр	тонн	25 932.8	12 325.9	18 739.9	8 275.4	30 031.9	12 485.8	160.3	150.9

## 5. ААНБ, ИРГЭДЭД ОЛГОСОН НИЙТ ЗЭЭЛ

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 5 дугаар сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 16.6 (0.1%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 795.6 (4.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.8 (51.2%) их наяд төгрөг нь иргэдийнх байна.

Хүснэгт 8. ААНБ, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн ангиллаар, сарын эцэст, тэрбум төгрөг

	2017 V	2018 V	2019 V	2020* V	2020* V / 2019 V
	тэрбум төгрөг				хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	12 711.5	14 979.6	17 982.8	17 187.2	95.6
Хэвийн зээл	10 622.9	12 818.7	15 187.4	14 069.6	92.6
Хугацаа хэтэрсэн зээл	930.3	940.8	821.0	1 145.6	139.5
Чанаргүй зээл	1 158.3	1 220.2	1 974.4	1 972.1	99.9

Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 5 дугаар сарын эцэст 14.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 77.2 (0.6%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 1.1 (7.4%) их наяд төгрөгөөр буурчээ. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 81.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.6 пунктээр буурсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 5 дугаар сарын эцэст 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 161.4 (12.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 324.6 (39.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.0 пунктээр өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 5 дугаар сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 100.9 (5.4%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 2.3 (0.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр өссөн байна.

## 6. ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш 2020 оны 5 дугаар сард 2797.25 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар, өмнөх сараас 0.5 хувиар суларсан байна.

Төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2020 оны 5 дугаар сард 393.69 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар, өмнөх сараас 0.1 хувиар суларсан байна.

Төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2020 оны 5 дугаар сард 38.39 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар чангарч, өмнөх сараас 3.6 хувиар суларсан байна.


Хүснэгт 9. Монголбанкнаас зарласан төгрөгийн гадаад валюттай харьцах сарын дундаж ханш, төгрөгөөр, жил бүрийн 5 дугаар сард

Үзүүлэлт	2017 V	2018 V	2019 V	2020 IV	2020 V	2020.VI.14
Америк доллар	2 413.06	2 405.19	2 645.16	2 783.16	2797.25	2 813.22
Жилийн өөрчлөлт,%	20.3	-0.3	10.0	5.6	5.7	
Сарын өөрчлөлт,%	-0.4	0.4	0.4	0.5	0.5	
Юань	350.38	377.39	385.97	393.46	393.69	397.56
Жилийн өөрчлөлт,%	14.0	7.7	2.3	0.3	2.0	
Сарын өөрчлөлт,%	-0.3	-0.7	-1.6	-0.3	0.1	
Рубль	42.30	38.57	40.75	37.06	38.39	40.38
Жилийн өөрчлөлт,%	38.6	-8.8	5.6	-9.1	-5.8	
Сарын өөрчлөлт,%	-1.4	-2.1	-0.1	-1.1	3.6	

## 7. АГААРЫН БОЛОН ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР

Хэдийгээр хорио цээрийн дэглэмд буй ч ачаа тээвэрлэлт, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг бууруулахгүй байх нь эдийн засгийн эргэлтийг хэвийн байлгахад чухал үүрэгтэй хэмээн үзэж, УОК-ын шийдвэрээр зарим боомтууд ажиллаж, ачаа тээврийн үйл ажиллагаа явагдаж байна.

Зураг 5. Төмөр замын тээврээр тээсэн ачаа, мянган тонн, сараар




Төмөр замын тээврээр 2020 оны эхний 5 сард 12.0 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.1 (9.9%) сая тонноор өссөн байна. Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд экспортын ачаа 1.1 (29.3%) сая тонн, импортын ачаа 94.9 (8.7%) мянган



тонноор тус тус өссөн нь нөлөөлжээ.

Төмөр замын тээврийн орлого 2020 оны эхний 5 сард 301.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 24.5 (8.8%) тэрбум төгрөгөөр өсөхөд уул уурхайн бүтээгдэхүүн, тухайлбал төмрийн хүдэр, жонш, нүүрсний тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 6. Агаарын тээврээр тээсэн ачаа, тонн, сараар



Агаарын тээврээр 2020 оны эхний 5 сард дотоодод 33.3 (2.5%) тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 1.9 (6.0%) тонноор өссөн байна. Харин олон улсад тээсэн ачаа 1.3 (97.5%) мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 874.4 (40.6%) тонноор буурчээ.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2020 оны 5 дугаар сард 119.0

тонн болж, өмнөх сараас 8.0 (7.2%) тонноор өссөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны эхний 5 сард 62.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 95.9 (60.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

## 8. БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА


Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ын 40 хувь нь худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг.

Худалдааны салбарын нийт борлуулалт 2020 оны эхний 4 сард 6.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 39.1 (2.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 665.2 (8.9%) тэрбум төгрөгөөр тус тус буурлаа.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 45.2 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байгаа ба жижиглэн худалдааны борлуулалтын орлого энэ эхний 4 сард 3.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 407.1 (11.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Улаанбаатар хотод нийт худалдааны салбарын 84.5 хувь ногдож байгаа бөгөөд Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалт 11.0 хувиар буураад байна.

Зураг 7. Худалдааны салбарын борлуулалт, тэрбум төгрөг



## 9. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2020 оны эхний 5 сард 9.4 мянган хүнд 21.6 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авагчид 490 (5.5%) хүнээр, олгосон тэтгэмжийн хэмжээ 5.4 (33.7%) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалд даатгуулагчид 2020 оны эхний 5 сарын байдлаар 924.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар өсөхөд сайн дураар даатгуулагчид 144.3 мянга болж, 6.2 хувиар буурсан хэдий ч албан журмаар даатгуулагчид 780.5 мянга болж, 1.9 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

2020 оны эхний 5 сард 2.2 (давхардсан тоогоор) сая хүнд 475.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 232.7 (12.0%) мянгаар өсөж, үйлчилгээнд олгосон тэтгэвэр,

тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 203.0 (74.6%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо нэмэгдэхэд “Хүүхдийн мөнгөн тэтгэмж” авсан 0-18 хүртэлх насны хүний тоо 231.7 (25.4%) мянгаар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж авагчид энэ оны эхний 5 сард 33.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (4.9%) мянган хүнээр, олгосон тэтгэмжийн хэмжээ 13.0 тэрбум төгрөг болж, 2.8 (27.7%) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

## 10. ЭРҮҮЛ МЭНД

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2020 оны эхний 5 сард 14.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 4278 (22.7%)-аар буурсан байна. Үүнд салхин цэцгээр өвчлөгчид 3918 (70.1%)-аар, цусан суулгаар өвчлөгчид 1047 (58.0%)-гоор, гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 606 (73.1%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 10. Халдварт өвчин, төрлөөр, жил бүрийн эхний улирлын байдлаар

Үзүүлэлт	2019 I-V	2020 I-V	$\frac{2020 \text{ I-V}}{2019 \text{ I-V}} \%$
Халдварт өвчнөөр өвчлөгчид	18 863	14 585	77.3
Цусаар дамжих	190	187	98.4
Вирусст гепатит	190	187	98.4
Амьсгалын замаар дамжих	8 110	3 486	43.0
Сүрьеэ	1 688	1 588	94.1
Салхин цэцэг	5 593	1 675	29.9
Гар, хөл, амны өвчин	829	223	26.9
Гэдэсний халдварт	1 805	758	42.0
Цусан суулга	1 805	758	42.0
Бэлгийн замаар дамжих	6 633	7 887	118.9
Тэмбүү	2 482	3 279	132.1
Гонококкт халдвар	2 329	2 417	103.8
Трихомониаз	1 818	2 184	120.1
ХДХВ/ДОХ	4	7	175.0
Бусад	659	1 719	260.8
Мөөгөнцөр	659	1 540	233.7
Коронавируст халдвар	-	179	-

Эх үүсвэр: ЭМЯ

Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварын замын төрлөөр харвал амьсгалын замаар дамжих халдварын тохиолдол 3486 болж, 4624 (57.0%)-өөр, гэдэсний халдварт өвчин 758 болж, 1047 (58.0%)-гоор тус тус буурсан байна.

Иргэд ЭМЯ-ны заавар, зөвлөгөөг сайн дагаж, гараа тогтмол угаан, амны хаалт зүүж хэвшсэн нь амьсгалын замын болон гэдэсний халдварт өвчин урьд байгаагүй доод түвшинд хүрч, буурахад нөлөөлсөн байна.

Харин бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол 7887 болж, 1254 (18.9%)-өөр нэмэгдсэн байна.

## 11. ГЭМТ ХЭРЭГ

Монголд хөл хорио тогтоож, өндөржүүлсэн бэлэн байдалд шилжээд 4 сар өнгөрч байна. Үйлчилгээний газар, баар, цэнгээний газруудыг хэсэгчлэн хааж, цагийн хуваарьт өөрчлөлт оруулсан мөн иргэдийг аль болох гэртээ байхыг уриалж байгаа нь энэ хугацаанд нийт гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлсөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 оны эхний 5 сард 12.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3635 (23.0%)-аар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 оны 5 дугаар сард 2549 болж, өмнөх сараас 26 (1.0%)-өөр буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2020 оны эхний 5 сард 47 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 162 (77.5%)-оор буурсан байна. Харин 2020 оны 5 дугаар сард 9 бүртгэгдэж, өмнөх сараас 1 (10.0%)-ээр буурсан байна.

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 2020 оны эхний 5 сард 1761 болж, өмнөх оны мөн үеэс 248 (16.4%)-аар өсөж, улсын хэмжээнд 43.3 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 6.9 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 2.2 (4.8%) мянгаар буурч, харин баривчлагдсан хүн 1.5 (27.5%) мянгаар өссөн байна.

## ДУГНЭЛТ

COVID-19 цар тахлын дэгдэлт болон БНХАУ-ын эдийн засгийн удаашралын улмаас ашигт малтмалын түүхий эдийн эрэлт багассан нь Монгол Улсын нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, газрын тосны экспорт буурч, эдийн засаг агшихад хүргэсэн байна.

Үүний нөлөөгөөр гадаад худалдааны нөхцөл муудаж, экспорт буурснаар төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал 2020 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 874.1 сая америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 442.3 сая америк доллароор өссөн байна.

Дэлхий нийтийг хамраад буй халдварт өвчний тархалт манай улсын боловсруулах аж үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлж байна. Нэн ялангуяа үйлдвэрлэлийн түүхий эд, материал болон сэлбэг, эд ангиа гаднаас импортолдог төмрийн үйлдвэрлэл, тамхи, химийн бүтээгдэхүүн, резин болон хуванцар бүтээгдэхүүн, хувцас, тавилга, нэхмэлийн үйлдвэрлэл 2020 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 2.9-52.5 хувиар буурсан байна.

Хэдийгээр хорио цээрийн дэглэмд буй ч ачаа тээвэрлэлт, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг бууруулахгүй байх нь эдийн засгийн эргэлтийг хэвийн байлгахад чухал үүрэгтэй хэмээн үзэж, УОК-ын шийдвэрээр зарим боомтууд ажиллаж, ачаа тээврийн үйл ажиллагаа явагдаж байна.

Төмөр замын тээврээр 2020 оны эхний 5 сард 12.0 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.1 (9.9%) сая тонноор өсөхөд уул уурхайн бүтээгдэхүүн, тухайлбал төмрийн хүдэр, жонш, нүүрсний тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 45.2 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байгаа ба жижиглэн худалдааны борлуулалтын орлого энэ оны эхний 4 сард 3.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 5 дугаар сарын эцэст 1.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 324.6 (39.5%) тэрбум төгрөгөөр өсөөд байна.

Иргэд ЭМЯ-ны заавар, зөвлөгөөг сайн дагаж, гараа тогтмол угаан, амны хаалт зүүж хэвшсэн нь амьсгалын замын болон гэдэсний халдварт өвчин доод түвшинд хүрч, буурахад нөлөөлсөн байна.

Үйлчилгээний газар, баар, цэнгээний газруудыг хэсэгчлэн хааж, цагийн хуваарьт өөрчлөлт оруулж, иргэдийг аль болох гэртээ байхыг уриалж байгаа нь хөл хорио тогтоогоод буй хугацаанд нийт гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлсөн байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ  
ҮНДЭСНИЙ ТООЦОО, ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ГАЗРЫН  
ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ТҮҮВРИЙН АЛБА